

XVII-XIX зууны Монголын анагаах ухааны мэс заслын багаж хэрэгслийн хэрэглээ, түүхэн тоймыг тодруулах нь

Халиунаа Б.¹, Баасанжав Н.¹, Болд Ш.²

¹“Ач” Анагаах ухааны их сургууль, ²Шинжлэх ухааны академи

Abstract

Historical Clarification and Review of Usage of Surgical Instruments in Mongolian Medicine from XVII to the XIX Century

Khaliunaa B.¹, Baasanjav N.¹, and Bold Sh.²

¹“Ach” Medical University and ²Mongolian Academy of Sciences

History of surgical services in Mongolian medicine began at least from New Stone Ages (Neolithic Era). However, we decided to study usage of surgical instruments in Mongolian medicine from 1578 to the XIX century. Because, the third transmission of Buddhism into Mongolia occurred during the time of the Altan Khan of the Southern branch of Central Mongols, a descendent of Kublai Khan, tried to revive Mongol strength and unification. After that Undur Gegeen Zanabazar was also holding a religious service around his residence. Furthermore, in 1651 he established 7 parts of the Monastery including Financial, Lamasery, Food service, and Personal physician's divisions based on his attendants, people, and lamas. The Personal physician's division was one of the basis for the sect of “Four Medical Tantras”. Since that time the sect of “Four Medical Tantras,” had been spread effectively and many medical schools were established near the Buddhist temples in Mongolia. They respected “Four Medical Tantras,” and “Shun,” as the main scripts and focused to base it on their theory and practice.

During the research we identified that from the XVII century, Mongolian doctors and scientists wrote many commentary books on “Four Medical Tantras” and renewed some of the content of “Four Medical Tantras.” Especially, Agvanluvsandanbijaltsan and Jambaldorj wrote a medical and medicinal books including surgical instruments. Also Ishbaljir wrote practical book about internal medicine, surgical methods, and services.

The major conclusion to this study was that Mongolian nation established their own medical art, comprehensive knowledge, and surgical methods as well as updated surgical instruments during the XVII and XIX Century. Particularly, they could renewed surgical methods and surgical instruments, which came from Indian Ayurveda and Tibetan medicine.

Key words: surgical instruments, Four Medical Tantras and surgical methods

Pp. 125-131, Figures 4, References 8

Үндэслэл

1990 оны цагаан морин жилээс эхлэн соёлын үнэт өвөө эргэн харж судлах, хэрэглэх, сурталчлах, сэргээн хөгжүүлэх сайхан боломж нээгдсэн билээ. Үүнтэй уялдан дотоод, гадаадын судлаачид, эмч нар Монголын анагаах ухааны түүхэн хөгжлийг сонирхон судлах явдал өсөн нэмэгдэж, Монголын анагаах ухаан 5000 жилийн түүхтэй гэдгийг археологийн олдвор, төвөд, хятад хэлээр бичигдсэн судар ном, сурвалж бичгийн баримтад үндэслэн тогтоож, 4 боть ном бичигджээ. Түүнчлэн гадаадын судлаачдын хамгийн түрүүнд “нэхдэг” зүйл бол Монголд эрт үеэс анагаах ухаан хөгжиж ирсэн түүхэн уламжлал байна уу?, Чингис хааны байгуулсан Их Монгол улсын үед Хархорум хотод

цуглуулсан өөрийн харьяанд байсан орнуудын анагаах ухааны өв хөрөнгө, ном, судар одоо хаана байна вэ?, Монгол уламжлалт анагаах ухаан Энэтхэгийн Аюурвед, Төвөд, Хятадын уламжлалт анагаах ухаанаас ямар ялгаа байна вэ? гэх мэт асуудлууд олонтоо гардаг. Монгол үндэстэн бүрэлдэн бий болж үржин олширч, амьдарч, тэмцэж, түүхийн нугачаанд өөдлөн дэгжиж, уруудан доройтож явахдаа амьд явах, эрүүл амьдрах урлаг, ухааны талаар бүхэл бүтэн цогц сургаал, мэдлэг, тогтолцоог үүдэн бүтээж хойч үедээ өвлүүлэн үлдээжээ. Өнгөрсөн зууны дунд үеэс уламжлалт мэдлэг ухаануудыг хэрэглэх, судлах явдал саарч үүнийг дагаад хэрэглээ ч багасаж, зарим мэдлэгүүд мартагдах шахсан байлаа. Ялангуяа уламжлалт

анагаах ухааны олон салбарууд түүний дотор гарын ур дүй, мэсээр засдаг аргууд, мэс заслын ухаантай холбоотой арга технологи, багаж хэрэгслийн хэрэглээ үнэ цэнэ буурч, зарим нь мартагдах шахсан байна.

Иймд бид уг асуудлыг шийдвэрлэх боломжийг судлах, Монголын анагаах ухаан дахь мэс заслын мэдлэг, түүнд хэрэглэж байсан багаж хэрэгсэлтэй холбоотой асуудлыг тусгайлан судалсан эрдэм судлалын ажил төдийлөн байхгүйд онцлон анхаарч судалгааны ажлын үндэслэл болгон энэхүү судалгааг хийлээ.

Зорилго

17-20 дугаар зууны эхэн үе хүртэлх Монголын анагаах ухаан дахь мэс засалд хэрэглэж байсан багаж хэрэгслийг судлах.

Материал, арга

Судалгаанд хэрэглэсэн материал

1. Bdud rtsi snying po yan lag brgyad pa gsang ba man ngag gi rgyud ces bya ba bzhugs so. Модон барын монгол судар
2. Агваанлуvsандамбийжалцан. Rgya dkar nag rgya ser kasmir bal bod hor gyi yi ge dang dpe ris nam grangs mang ba bzhugs so (Энэтхэг, хятад, орос, кашмир, балба, төвөд, монгол үсэг болон үлгэр зургийн олон зүйл оршивай). Гар бичмэл төвөд судар.
3. Жамбалдорж “Анагаан үйлдэгч рашааны нүүрийг эндүүрэлгүй танин барих урлахуй ухааны толинд дүр тодруулсан гайхамшигт үзэсгэлэнт нүдэн чимэг оршвой.” Модон барын төвөд судар. Жамбалдорж. “Монгол эмийг зөв таних толь” (Орчуулсан Гэндэнжалцан). ӨМ-ын ШУТМХХ, 2015
4. Гэлэн Ишдондовданбийжалцан (Жамбалдорж). འོ་མེད་ཤེས་ཐེང་ནས་བཤད་པའི་
སྐབས་ཀྱི་འཕྲུངས་དཔེ་མཛོན་མཚན་མིག་རྒྱན་ཅེས་བྱ་བ་བཞུགས་སོ།
Хиргүй болор эрхид номлосон эмээс ирсэн жишээ загвар үзэсгэлэнт нүдэн чимэг хэмээх оршивай

Судалгаанд хэрэглэсэн арга

1. Эх бичиг, сурвалж бичгийн судлалын арга

Бид судалгаанд ашигласан эх сурвалжуудаа ажлынхаа зорилгод нийцүүлэн цаг хугацаагаар нь эрэмбэлэн судалгааг хийж, мэс заслын багаж хэрэгсэлтэй холбоотой хэсгийг харьцуулан, шүүн тунгааж үзэв. Эх бичиг, сурвалж судлалыг тэмдэгтийн арга (семиотические), тухайн

бүтээлийн зөвхөн нэг хэсгийг бус бүх хэсгийг авч үзэх цогц бүрдлийн аргатай хослуулан хэрэглэдэг. Бид ч мөн энэ зарчмаар уг аргыг хэрэглэв. Мөн эх бичгийн судалгаанд тавигдах үндсэн шаардлагын дагуу түүхэн явдал, тухайн бүтээл нийгэм түүхийн нөхцөл байдалтай, соёл, түүхэн уран зохиолын контексттэй холбогдсон холбоо, тухайн эх сурвалжийн өөрчлөлтийн судалгаа, тухайн бүтээлийн агуулга өөр эх сурвалжид тусгалаа олсон эсэх талаар эрэл хайлт хийв.


2. Магадлан жагсаах арга

Магадлан жагсаах буюу хяналтын хуудасны арга нь уламжлалт анагаах ухааны мэс заслын багаж, хануур заслын бүрэлдэхүүн хэсгийг төрөлжүүлэн жагсааж, тэдгээрийг тодорхойлсон хэсгийг судлах арга юм. Магадлан жагсаах арга нь мэдээллийг төрөлжүүлж ангилахад хялбар, өгөгдөл цуглуулахад хялбар, эхний шатны үнэлгээ өгөхөд тохиромжтой, төлөвлөсөн ажлаа урьдчилан харах, цахим санд оруулахад зохимжтой, хялбар байдгаараа давуу талтай арга юм.

Үр дүн

Монголын анагаах ухааны мэс заслын шинжлэх ухааны түүхийг сөхвөл наад зах нь шинэ чулуун зэвсгийн үеэс эхэлнэ. Гэвч бид энэ удаагийн судалгаандаа Монголд буддын шашны шарын урсгал дэлгэрсэн үе буюу тухайлбал 1578 оноос нааших үеийг, Монгол оронд буддын шашны их 5 ухааны нэг тэжээхүй ухааны мэдлэгт суурилсан Мамба дацан (Эмчийн сургууль)-гийн суурь болох 1651 онд байгуулагдсан Хүрээний “Дархан эмч”-ийн аймаг, 1681 онд Ламын гэгээний байгуулсан “Мамба дацан”-гаас хойших үеийг хамрууллаа.


17 дугаар зуунаас хойш Монголын анагаах ухааны мэс заслын салбарт шинэчлэл хийгдэж хөгжлийн шинэ шатанд гарчээ. Уг шинэчлэлийн эх сурвалж нь Энэтхэгийн Аюурведийн анагаах ухааны мэс заслын гол бүтээл “Сушрута самхита”-аас үүсэлтэй юм (Зураг 1) [1]. “Сушрута самхита” нь Энэтхэгийн Аюурведийн анагаах ухааны мэс заслын чиглэлийг хөгжүүлсэн, мэс заслын эцэг гэгддэг Сушрута анх эмхэтгэн нэгтгэн АТӨ 600 орчим онд бичиж, бие даасан сургууль болгон хөгжүүлсэн байна. Энэ бүтээлд буй мэс заслын багажуудыг Төвөд, Монголын эмч, эрдэмтэд, “Анагаах ухааны дөрвөн үндэс”-ийн онол, өвчний ангилал зүй, оношилгоо, эмчилгээний аргуудтай нийцүүлэн шинэчлэл хийж, нэр, хэрэглээг тодруулж өгчээ.



Зураг 1. “Сушрута самхита” сударт дурдсан мэс заслын багажууд
www.livehistoryindia.com

“Анагаах ухааны дөрвөн үндэс” (Bdud rtsi snying po yan lag brgyad pa gsang ba man ngag gi ggyud ces bya ba bzhuugs so) судар [2] нь монгол эмч нарыг бэлтгэх үндсэн сурах бичиг болсоор ирсэн бөгөөд үе үеийн сор болсон эмч, маарамбууд уг зохиолын тайлбар ном олныг бичиж гар бичмэл болон барлуулан монгол хөрсөнд буулгахад үнэтэй хувь нэмрээ оруулжээ (Зураг 2). Мамба дацангийн сургалтын гол технологи нь цээжлүүлэх, багшийн тайлбар,

практик гэсэн дараалалтай, шүнгийн ном “Анагаах ухааны дөрвөн үндэс”-ийг 4 хуваан, 4 зиндаа болгон зиндаа бүртээ анги дэвших шалгалт өгдөг байжээ. Анги дэвших байдал нь “язгуурын үндэс”-ийн зиндаад 2 жил, “Шад-жүд” буюу “Номлолын үндэс”-ийн зиндаанд 3 жил, “Хойд үндэс”-ийн зиндаанд 3-4 жил, “Увдисын үндэс”-ийн зиндаанд 5-6 жил орчим суралцаж 14-15 орчим жил болж анги зиндаа бүрт шалгалт, шүүлэг өгч дэвшин суралцдаг байжээ.



Зураг 2. “Анагаах ухааны дөрвөн үндэс”-т дурдсан мэс заслын багажууд

Мамба дацангийн шавь нар эдгээр багажуудын хэрэглэх аргыг бүрэн цээжилж, шавилан суралцах явцдаа хусах, огтлох, цоолох, хайрах, оёх, ханах, төөнөх, хатгах зэрэг аргад сайтар суралцдаг байв. Түүнчлэн багшийнхаа хэрэглэдэг багажийг дуурайлган сайн дарханд захиалан хийлгэж, төгсөж гараад өөрийн практикт ашигладаг байжээ.

Мэс заслын багажийн талаарх бүтээлүүд

Бид судалгааны явцад мэс заслын багажийн талаар өөрсдийн бүтээлдээ тодорхой бичиж үлдээсэн монгол эмч, эрдэмтдийн зарим бүтээлийг тодруулав.

1. Арьяа жонлун бандида хэмээн алдаршсан Агваанлуvsандамбийжалцан 1770 он (XIII равжингийн цагаан барс жил, Тэнгэр Тэтгэгчийн 35 дугаар он), билгийн улирлын 2 дугаар сарын 1-ний өглөө зүүн Сөнөдийн хошууны боржигон овогт Дондовын отгон хөвгүүн болж мэндэлжээ. Тэрбээр ихэнх насаа Бандид гэгээн сүм дээр шашин номын үйлс эрхлэхийн зэрэгцээ ном туурвих, шавь нартаа бурхны шашны гүн ухаан, анагаах ухааныг заан сургах, өвчтөн үзэх ажлыг хийж байв. Тухайлбал: 1808 онд 39 настайдаа Гэгээн хийдийн бурхан тахилын зүйлийг ихээр нэмж, "Анагаах ухааны дөрвөн үндэс", "Увдисын үндсийн нөхвөр" зэргийг шавь нартаа соёрхон, анагаах ухааны онол, дадлагыг ёсчилон зааж, эмч бэлтгэх үйлсэд хүчин зүтгэв.

2013 онд хэвлэгдсэн "Монгол эрдэмт лам нарын төвөд хэлээр туурвисан зохиол, бүтээлийн ном зүй" бүтээлд: Агваанлуvsандамбийжалцангийн 6 ботид 158 зохиол, давхардсан тоогоор 777 ном байна гэсэн тоог гаргажээ.

Агваанлуvsандамбийжалцаны бүрэн зохиолын дотор анагаах ухааны дөрвөн зохиол байна. Үүнээс мэс заслын анагаах ухаанд өргөн хэрэглэдэг мэс заслын багажийн зураг болон хий бясалгалын дасгалын хөдөлгөөнийг дүрсэлсэн зургуудийг багтаасан Rgya dkar nag gyu ser kasmir bal bod hor gyi yi ge dang dre ris nam grangs mang ba bzhugs so (Энэтхэг, хятад, орос, кашмир, балба, төвөд, монгол үсэг болон үлгэр зургийн олон зүйл оршивай) гар бичмэл төвөд судар бий. Уг сударт "Анагаах ухааны дөрвөн үндэс" зохиолын "Номлолын үндэс"-ийн 22 дугаар бүлэгт дурдсан мэс заслын багажийн 82 зураг байдаг бөгөөд тухайлбал: мэс заслын хутга, оёдол тавьдаг зүү, хямсаа, хөрөө, таван заслын зүү, хатгуур, алтан төөнө, хануурын багаж, соруул зэрэг зургууд буй [3].

2. Найман тойн Жамбалдорж XIII жарны усан хулгана жил, 1792 онд Найман хошууны есдүгээр засаг төрийн дархан ван, Чингис хааны угсаа болох эцэг Балчиг хийгээд эх Балмо хоёрын хоёрдугаар хөвгүүн болж заяасан бөгөөд эцэг, эх нь түүнд Жамбалдорж гэдэг нэр хайрлажээ. Сахилын нэрийг нь Ишдондовданбийжалцан гэдэг. Зарим бүтээл нь энэ нэрээр бичигдсэн байдаг. Жамбалдорж буддын шашины их 5 ухаанд нэвтэрсэн, монгол, хятад, төвөд хэлийг чөлөөтэй эзэмшсэн, өөрийн сүмийн сахил санваар, хурал номын дэг жаяг, өргөл магтаал зэргийн талаар багагүй бүтээл туурвисан мэдээ байдаг. Тэрбээр Анагаан үйлдэгч рашааны нүүрийг эндүүрэлгүй танин барих урлахуй ухааны толинд дүр тодруулсан гайхамшигт үзэсгэлэнт нүдэн чимэг оршвой", "Хиргүй болор эрхид номлосон эмээс ирсэн жишээ загвар үзэсгэлэнт нүдэн чимэг хэмээх оршивай" гэсэн зохиол бичжээ (Зураг 3). Энэ хоёр зохиолыг гадаад, дотоодын эрдэмтэд өнгөрсөн зууны дунд үеэс судалсаар өнөөг хүрч иржээ. .

Энэ бүтээлд мэс заслын багажийг 5 хэсэг болгон хувааж бичсэн байна [4]. Үүнд:

Нэг. Эвэршээлийг шинжлэх багаж

1. Эвэршээлийг шинжлэх багаж - 7
2. Заслын багаж – 6

Хоёр. Мэс хоцорсныг гаргах багаж

3. Хавчаар - 3
4. Хямсаа – 4

Гурав. Махыг хагалж цус гаргах багаж


5. Хануурын хутга – 6

Дөрөв. Мах зэргийг нүхлэх хутганууд

6. Нүхлэх хутганууд – 8

Тав. Зүйл бүрийн нарийн багаж

7. Жижиг багаж – 5
8. Хөрөө – 5
9. Хатгуур – 3
10. Төөнүүр - 3
11. Хамраар утаа соруулах багаж – 1
12. Гадар бэтгийг татах соруул – 4
13. Илүүр - 1
14. Үс хяргах хутга - 1
15. Мах оёх зүү - 1
16. Тунгийн халбага -1



Зураг 3. Ишдондовданбийжалцан (Жамбалдорж). “Хиргүй болор эрхид номлосон эмээс ирсэн жишээ загвар үзэсгэлэнт нүдэн чимэг хэмээх оршивай” судрын багаж, хэрэгслийн зураг

Мэс заслын хэрэглээ, аргыг тодруулах нь

Монгол эмч, маарамбууд дотроос мэс засалд нэн дадамгай бөгөөд гар сайтай эмч нар олон байсны нэг нь Сүмбэ хамба Ишбалжир бөгөөд тэрбээр мэс заслын ухаанд онцгой байр эзэлдэг нь түүний бүтээлээс тодорхой байна. Ишбалжирын “Дөрвөн рашаан”-ны “Рашааны цагаан шүүдэр” номын 29 дүгээр бүлэгт: Хошногоны гүвдрүү, 30 дугаар бүлэгт: Давсагны өвчин (Шээс хаагдах, ба чулуушрах шижин)-ийг мэс заслаар анагаах талаар тус тус бичиж үлдээжээ [5].

29 дүгээр бүлэг: Хошногоны гүвдрүү

Гүвдрүүг огтолж болмоор бол огтолж аваад хайрна. Эдгээрээр эс болвоос бөгсийг нь бүтээж, зөвхөн баасны сүвд гэрэл тусахаар болгож үзүүр ба хажуудаа нүхтэй гуурс хийж оруулаад эргүүлж үзнэ. Гүвдрүү байх газрыг олж хажуудаа нүхтэй гуурс хийж гүвдрүүг тэр нүхэнд

шахаж оруулаад гуурсандаа яг тааруулж хурц хусуураар хусаж аваад ором дээр нь хайруул тавьж тав үүсгэн улмаар тос түрхэж орхино. Үлдсэн гүвдрүүг нь 7 хоногийн дараа авах бөгөөд удаа бүр нь нэг л огтолж авна гэжээ.

30 дугаар бүлэг: Давсагны өвчин

(Шээс хаагдах, ба чулуушрах шижин)

Давсагны доторх жижиг чулуун мөхлөг нь давсагны амсраар гарч ирэн сүвийг бөглөнө. Үүнийг хагалж авч болох газар нь хагалж авах бөгөөд шархан дээр нь тос түрхэж, жин тавина.

Чулуу нь давсагны дотор байх үед өвчтнийг өлсгөж байгаад салтаанд нь тос түрхэж мод зайдлуулан тонгойлгон хэвтүүлж 2 хөлийг нь атийлган туслагчаар туслуулна. Эмч хумсаа авч гартаа тос түрхэж зүүн гарын дунд хурууг өвчтөний хошноогоор оруулж, баруун гарын хуруунуудаараа дарсхийн тэмтэрч чулууг олж тогтооно. Чулууг олвол нааш гадагш нь хөөн

ирүүлж эрэгтэй бол зүүн, эмэгтэй бол баруун талд нь тус тус нүхэлж чулууг гаргаад шархыг нь анагаана гэжээ. Энэ 2 баримт монголчууд мэс заслын ухааныг хөгжүүлэн өөрийн гэсэн арга технологитой, эмчлэх дадалтай байсны зэрэгцээ эдгээр аргууд нь Энэтхэг, Төвөдийн анагаах ухааны номуудад тэмдэглэснээс өөр, дэвшилттэй байсан харагдаж байна.

Хануур заслын багажууд

Судалгааны дараагийн чиглэл нь хануур заслын багажийг гүнзгийрүүлэн судлахад оршиж байв. Учир нь монгол эмч нар хануур засал хийхдээ дорно дахинд ихэд нэрд гарч байжээ. Тиймээс монгол дархчууд хануурын багажийг маяг сайтай, бөх, хэрэглээнд нэн тохируулан хийж иржээ.

“Анагаах ухааны дөрвөн үндэс”-ийн “Хойд үндэс”-д хануурын хэлбэрийг дараах хэдэн зүйлээр тэмдэглэсэн байна [6]. Жишээлбэл: Болжморын сүүлний өд хэлбэртэй, хадуурын ир хэлбэртэй, шулуун ирт, шинийн хоёрны сар хэлбэртэй, сүхний ир хэлбэртэй, үсний хутга хэлбэртэй, илдний ир хэлбэртэй зэрэг олон зүйл байдаг.


Ерөнхийдөө ган сайтай, харимхай чанар төгөлдөр төмрийг гүйцэд давтаж байгаад хавтгай

бөгөөд урлаг сайтай хийлгэдэг байв.

Гэхдээ бараг гурван ямх хэртэй урт хялгасыг босоогоор нь зүсч чадахаар хурц иртэй бол нэн сайн хэмээдэг байсан байна. Учир нь хануурын ир хурц бол ханахад судас шилжилгүй хялбар оногдохоор барахгүй, бас өвтгөхгүй мөртлөө сорви тогтохгүй байх давуу талтай. Иймээс хануурын ир хурц байх нь чухал юм.

Ханах судасны онцлог ба оршиж байгаа орных нь байрлалыг үндэслэж, өөр өөр хэлбэртэй хануурыг сонгож хэрэглэдэг. Тухайлбал:

1. Тэгш ирт (сүхэн ирт). Сүхний ир шиг тэгш бөгөөд ир нь нимгэн, мөр тийшээ зузаан, тохирсон иштэй. Үүнийг магнайн судас мэтийн ясны судсуудыг ханахад хэрэглэнэ.
2. Жадан хануур (өд хэлбэрт), жад шиг хэлбэртэй үзүүр ба уг тийш шувтан дундаа өргөн ар, өвөр нь бага зэрэг хөтгөр, ир нь өргөн хэсгээсээ дээш хоёр хажуу болон үзүүртээ байдаг. Болжморын сүүлний өд хэлбэртэй хануурыг гарын хэсэг дэх судсууд буюу эсвэл булчингийн завсар дахь судсыг ханана. Дараах зурганд монгол маарамбын байнга хэрэглэдэг хануур заслын багажны иж бүрдлийг үзүүлэв (Зураг 4) [7].



Зураг 4. Монгол маарамбын хэрэглэдэг хануур заслын багажны иж бүрдэл

Түүнчлэн дагзны судас мэтийг ханахад үсний хутга хэлбэртэй хануурыг хэрэглэнэ. Гүрээний судас буюу хэлний судсыг ханахад шинийн хоёрны сар хэлбэртэй хануурыг хэрэглэнэ. Шаггайн судас мэтийг ханахад хагас саран хануурыг сонгож хэрэглэнэ. Их судсуудыг ханахад илд хэлбэртэй хануурыг сонгож хэрэглэнэ. Гэвч сүүлийн үед ихэнхдээ гурвалжин хануур, жад хэлбэрт хануур болон тэгш ирт (сүхэн ирт) ба ховилт хануурыг хэрэглэж байна.

Ханах засал хийх багажийг янз бүрийн төмөрлөгийн зүйл ашиглан хийдэг. Үүнд:

1. Дан төмөрлөг. Үүнд: алт, мөнгө, зэс, төмөр, болд зэрэг төмөрлөгийн зүйл багтана. Эдгээрийн зарим нь чанараар зөөлөн тул хурц бус. Зарим нь чанараар хатуу боловч харимхай чанар дутмаг тул хялбархан хугарах буюу нугарах гэм гардаг. Жишээлбэл: Алт буюу мөнгө бол уян зөөлөн чанартай боловч хурц хатан чанар муутай юм. Болд ба төмөр бол хатуу чанартай бөх боловч харимхай чанар муу. Иймээс дан төмөрлөгийн зүйлээр хийсэн хануур бол бодит хэрэглээнд төдий л тохиромжтой бус байдаг.

2. Холимог төмөрлөг. Дээр дурдсан төмөрлөгийн зүйлээс хольж үйлдсэн хануур бол өнгө нь гоё сайхан гөлгөр бөгөөд гялтганасан, зэврэх нь бага, хатуу зөөлөн нь тэнцүү, зохих хэмжээний харимхай чанартай тул холимог төмөрлөгөөр хийсэн хануур хэрэглэхэд тун тохиромжтой байдаг [8].

Монгол үндэстэн Төв азийн төв хэсэгт бүрэлдэн бий болж, амьдарч тэмцэж, ирэхдээ амьд явах, эрүүл амьдрах урлаг, ухаан, мэс засал, заслын талаар цогц мэдлэгтэй түүнийгээ хөрш оны анагаах ухааны мэдлэгээр баяжуулан, өөрсдийн туршлагаар боловсронгуй болгосоор байсан нь сурвалж бичигт тэмдэглэгдэн, эд өлгий зүйлээр баримт болон үлджээ. Одоо гагцхүү эдгээр мэдлэгийг улам гүнзгий нээн илрүүлж

судлах, хэрэглээг нь тогтоох, зарим мартагдсан ухааныг сэргээн хөгжүүлэх нь чухал гэдэг нь судалгаанаас харагдаж байна.

Ном зүй

1. Sushruta Samhita: The Ancient Treatise on Surgery. www.livehistoryindia.com/snapshort-histories. Хандалт хийсэн 2018.08.03
2. Bdud rtsi snying po yan lag brgyad pa gsang ba man ngag gi rgyud ces bya ba bzhugs so. Модон барын монгол судар
3. Агваанлуvsандамбийжалцан. Rgya dkar nag rgya ser kasmir bal bod hor gyi yi ge dang dpe ris rnam grangs mang ba bzhugs so (Энэтхэг, хятад, орос, кашмир, балба, төвөд, монгол үсэг болон үлгэр зургийн олон зүйл оршивай). Гар бичмэл төвөд судар
4. Жамбалдорж “Анагаан үйлдэгч рашааны нүүрийг эндүүрэлгүй танин барих урлахуй ухааны толинд дүр тодруулсан гайхамшигт үзэсгэлэнт нүдэн чимэг оршвой.” Модон барын төвөд судар.
5. “Рашааны цагаан шүүдэр”-Төвөд эх бичиг, монгол бичгийн орчуулгыг хавсруулан шинэ бичигт буулгасан Ш.Болд, Б.Дагвадорж. УБ, 1997,
6. Bdud rtsi snying po yan lag brgyad pa gsang ba man ngag gi rgyud ces bya ba bzhugs so. Модон барын монгол судар
7. Уламжлалт анагаах ухаанд суралцагсдын гарын авлага. УБ, 2005, х.137
8. Уул Б. Монгол эмнэлгийн уламжлалт заслын болор эрхи. Хөх хот, 2000, х.64

*Танилцаж, нийтлэх санал өгсөн:
Анагаах ухааны доктор, профессор
Д.Цэрэндагва*